



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2025/31/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Дундговь аймаг

2025 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох  
Утас: 70592439  
Цахим хаяг: [Munkhtogtokhr@audit.gov.mn](mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn)

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ  
Утас: 70592225  
Цахим хаяг: [Oyunerdenet@audit.gov.mn](mailto:Oyunerdenet@audit.gov.mn)

Ахлах аудитор: Т.Батсайхан  
Утас: 70593113  
Цахим хаяг: [Batsaikhant@audit.gov.mn](mailto:Batsaikhant@audit.gov.mn)

Аудитор: Д.Должинсүрэн  
Утас: 70593113  
Цахим хаяг: [Doljinsurend@audit.gov.mn](mailto:Doljinsurend@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

<b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>2</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....</b>	<b>4</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	9
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>9</b>
3.1 Төлбөрийн акт .....	9
3.2 Албан шаардлага.....	9
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>16</b>
<b>5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл.....</b>	<b>17</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ЭЭС	Эм эргэлтийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2025.02.25 № 49

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

### ДУНДГОВЬ АЙМГИЙН ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ш.МӨНХ-ОРГИЛ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтны цалинг 100 хувиар тогтоож, 3.5 сая төгрөг илүү олгосон, хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвийн шууд захирагчид 1.8 сая төгрөгийн урамшуулал олгосон, санхүүгийн албан хаагчдын ажлыг дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр 2.9 сая төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон, төсвөөс гаргах баяр наадмын зардлыг санхүүжилтийн жишиг дээд хэмжээнээс 21.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 3 дахин их байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь, Хөдөлмөрийн тухай хуулийн 57.1, 57.3.3, Засгийн газрын 2010 оны 271 дугаар тогтоолын "Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай /наадмын санхүүжилт/"-ийн 1-д заасан заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх мэдэгдлийг хангахгүй байна.

#### Асуудлыг онцолсон хэсэг

4825320223

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 сарын сарын 01-ээр төрийн албаны үндсэн цалин нэмсэн, бүх төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг олгож эхэлсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 155.1 сая төгрөгөөр өссөн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 16 дугаар тогтоолын дагуу сумдын Эмийн эргэлтийн санг татан буулгах шийдвэр гарч, тус сумын Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 13.4 сая төгрөгийн хөрөнгө, 28.6 сая төгрөгийн өр төлбөрийг ЗДТГ-ын санхүүгийн тайланд нэгтгэн бүртгэсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 18 зорилт, 79 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 65 арга хэмжээг бүрэн, 14 арга хэмжээг дутуу хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 83.3 хувьтай үнэлэгдсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	96,245,185.59	198,317,207.38
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	989,567.66	219,567.66
312	Банканд байгаа бэлэн мөнгө	989,567.66	219,567.66
3121	Төгрөг	989,567.66	219,567.66
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	989,567.66	219,567.66
33	АВЛАГА	20,000,000.00	10,043,164.99
335	Бусад авлага	20,000,000.00	10,043,164.99
3351	Байгууллагаас авах авлага	20,000,000.00	
3352	Хувь хүмүүсээс авах авлага		10,043,164.99
35	БАРАА МАТЕРИАЛ	75,255,617.93	188,054,474.73
351	Түүхий эд материал	33,857,248.03	148,258,804.83
3511	Тусгай зориулалттай материал	33,857,248.03	148,258,804.83
354	Хангамжийн материал	41,398,369.90	39,795,669.90
3541	Бичиг хэргийн материал	724,000.00	
3542	Аж ахуйн материал	1,764,569.90	1,295,669.90
3544	Түлш, шатах тослох материал	357,000.00	
3545	Барилгын засварын материал	52,800.00	
3547	Бусад хангамжийн материал	38,500,000.00	38,500,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,221,590,000.36	1,301,549,157.52
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,221,590,000.36	1,301,549,157.52
391	Газар	8,680,000.00	8,680,000.00
392	Биет хөрөнгө	1,186,315,375.36	1,268,525,711.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,075,511,050.08	1,148,944,315.45
39202	Хуримтлагдсан элэгдэл	-155,387,651.78	-187,345,601.38
39203	Авто-тээврийн хэрэгсэл	269,616,393.73	322,120,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-151,496,232.50	-161,171,110.64
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	211,837,437.00	218,962,558.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-114,659,032.55	-122,642,077.58
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,491,400.00	31,277,579.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-29,238,900.00	-29,144,300.23
39214	Бусад үндсэн хөрөнгө	65,082,088.93	64,522,381.96
39215	Хуримтлагдсан элэгдэл	-16,441,177.55	-16,998,033.06
393	Биет бус хөрөнгө	26,594,625.00	27,719,125.00
39301	Программ хангамж	4,786,625.00	5,911,125.00
39303	Бусад биет бус хөрөнгө	21,808,000.00	21,808,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,317,835,185.95	1,503,242,043.90
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,222,437.00	34,776,433.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,222,437.00	34,776,433.00
413	Өглөг	6,222,437.00	34,776,433.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	6,187,437.00	6,187,437.00
4136	Бусад өглөг	35,000.00	28,588,996.00
41361	Байгууллагад төлөх өглөг		28,588,996.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	35,000.00	
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,311,612,748.95	1,468,465,610.90
51	Засгийн газрын хувь оролцоо	1,311,612,748.95	1,468,465,610.90
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	348,361,676.40	348,361,676.40
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	348,361,676.40	348,361,676.40
512	Хуримтлагдсан үр дүн	692,007,919.52	845,485,102.47
5121	Өмнөх үеийн үр дүн	692,007,919.52	692,007,919.52
5122	Тайлант үеийн үр дүн		156,852,861.95
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	271,243,153.03	271,243,153.03
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,317,835,185.95	1,503,242,043.90

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	821,042,511.12	1,221,198,316.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	315,907,373.12	329,578,853.90
120	Нийтлэг татварын бус орлого	315,907,373.12	329,578,853.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,868,314.66	1,061,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,869,767.66	1,061,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19,998,547.00	
120009	Бусад орлого		4,965,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	259,039,058.46	193,237,453.90
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	34,000,000.00	140,244,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	505,135,138.00	891,619,463.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,241,638.00	34,811,263.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		5,610,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,241,638.00	29,006,063.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		195,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	487,893,500.00	856,808,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	487,893,500.00	856,808,200.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	581,044,527.16	1,013,335,504.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	581,044,527.16	1,013,335,504.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	540,950,192.06	983,726,847.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	306,651,440.38	461,753,135.51
210101	Үндсэн цалин	214,802,396.96	291,281,593.40
210102	Нэмэгдэл	58,643,203.07	149,812,338.51
210104	Урамшуулал	33,205,840.35	20,659,203.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,331,430.03	57,742,876.47
210201	Тэтгэврийн даатгал	26,065,372.34	39,249,016.54
210202	Тэтгэмжийн даатгал	3,066,514.30	4,617,531.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,453,211.64	2,334,500.19
210204	Ажилгүйдлийн даатгал	613,302.92	2,308,765.69
210205	Эрүүл мэндийн даатгал	6,133,028.83	9,233,062.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,560,455.69	40,091,959.16
210301	Гэрэл, цахилгаан	3,977,668.69	4,121,507.16
210302	Түлш, халаалт	32,532,987.00	35,970,452.00
210303	Цэвэр, бохир ус	49,800.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	37,418,550.00	48,590,840.00
210401	Бичиг хэрэг	2,585,000.00	4,078,180.00
210402	Тээвэр, шатахуун	18,600,100.00	24,417,660.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,406,400.00	2,925,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,200,000.00	1,548,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,527,050.00	13,574,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		2,047,500.00
210408	Бараа материал ақталсны зардал	100,000.00	
2105	Нормативт зардал		1,100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		1,100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,669,500.00	31,000,000.00
210604	Урсгал засвар	1,669,500.00	31,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	12,717,800.00	17,588,000.00
210702	Дотоод албан томилолт	12,717,800.00	17,588,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,161,194.80	3,831,595.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,262,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	231,750.00	916,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	373,000.00	466,777.60
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,500.00	77,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	80,000.00
210807	Газрын төлбөр	107,944.80	29,818.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	106,439,821.16	322,028,440.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,706,769.00	207,895,942.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,181,900.00	2,694,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	83,551,152.16	111,438,498.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,094,335.10	29,608,656.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,167,500.00	7,650,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,867,500.00	7,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	650,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	32,926,835.10	21,958,656.66
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,926,835.10	21,888,656.66
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		70,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	239,997,983.96	207,862,812.62
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		51,009,950.67
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		20,564,830.63
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		28,588,996.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө		1,856,124.96
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		-51,009,950.67
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	239,997,983.96	156,852,861.95

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	508,039,905.66	892,681,063.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,904,767.66	1,061,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,904,767.66	1,061,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,904,767.66	1,061,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,218,600.00	1,061,600.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	1,686,167.66	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	505,135,138.00	891,619,463.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,241,638.00	34,811,263.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		5,610,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,241,638.00	29,006,063.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		195,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	487,893,500.00	856,808,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	487,893,500.00	856,808,200.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	505,655,938.00	893,451,063.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	505,655,938.00	893,451,063.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	465,211,602.90	863,842,406.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	306,651,440.38	461,753,135.51
210101	Үндсэн цалин	214,336,420.96	291,281,593.40
210102	Нэмэгдэл	59,109,179.07	149,812,338.51
210104	Урамшуулал	33,205,840.35	20,659,203.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,331,430.03	57,742,876.47
210201	Тэтгэврийн даатгал	26,065,372.34	39,249,016.54
210202	Тэтгэмжийн даатгал	3,066,514.30	4,617,531.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,453,211.64	2,334,500.19
210204	Ажилгүйдлийн даатгал	613,302.92	2,308,765.69
210205	Эрүүл мэндийн даатгал	6,133,028.83	9,233,062.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,373,018.69	40,091,959.16
210301	Гэрэл, цахилгаан	3,977,668.69	4,121,507.16
210302	Түлш, халаалт	26,345,550.00	35,970,452.00
210303	Цэвэр, бохир ус	49,800.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	25,528,500.00	35,889,940.00
210401	Бичиг хэрэг	3,100,000.00	3,432,180.00

210402	Тээвэр, шатахуун	16,422,100.00	26,022,760.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,406,400.00	2,925,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,300,000.00	1,548,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,000.00	1,962,000.00
2105	Нормативт зардал	650,000.00	1,100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	650,000.00	1,100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,138,200.00	16,000,000.00
210604	Урсгал засвар	18,138,200.00	16,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	12,717,800.00	17,588,000.00
210702	Дотоод албан томилолт	12,717,800.00	17,588,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,237,194.80	44,211,595.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,076,000.00	42,642,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	231,750.00	916,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	373,000.00	466,777.60
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,500.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	80,000.00
210807	Газрын төлбөр	107,944.80	29,818.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,584,019.00	189,464,899.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,246,119.00	186,714,899.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,337,900.00	2,750,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,444,335.10	29,608,656.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,517,500.00	7,650,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,867,500.00	7,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	650,000.00	650,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	32,926,835.10	21,958,656.66
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,926,835.10	21,888,656.66
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		70,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,383,967.66	-770,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,394,400.00	
	Дотоод эх үүсвэрээр	1,394,400.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,394,400.00	
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1,394,400.00	
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	989,567.66	-770,000.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		989,567.66
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	989,567.00	219,567.66

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	348,361,676.40	271,243,153.03	692,007,919.52	1,311,612,748.95
17	Тайлант үеийн үр дүн			156,852,861.95	156,852,861.95
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	348,361,676.40	271,243,153.03	848,860,781.47	1,468,465,610.90

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	857,308,200.00	835,981,143.34	21,327,056.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	849,658,200.00	828,331,143.34	21,327,056.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	849,658,200.00	828,331,143.34	21,327,056.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	472,215,700.00	461,753,135.51	10,462,564.49
210101	Үндсэн цалин	295,424,200.00	291,281,593.40	4,142,606.60
210102	Нэмэгдэл	153,715,100.00	149,812,338.51	3,902,761.49
210104	Урамшуулал	20,659,300.00	20,659,203.60	96.40

210105	Гэрээт ажлын хөлс	2,417,100.00	0.00	2,417,100.00
<b>2102</b>	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,300,600.00	57,742,876.47	2,557,723.53
210201	Тэтгэврийн даатгал	40,954,300.00	39,249,016.54	1,705,283.46
210202	Тэтгэмжийн даатгал	4,832,400.00	4,617,531.34	214,868.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,430,600.00	2,334,500.19	96,099.81
210204	Ажилгүйдлийн даатгал	2,430,600.00	2,308,765.69	121,834.31
210205	Эрүүл мэндийн даатгал	9,652,700.00	9,233,062.71	419,637.29
<b>2103</b>	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,270,500.00	40,091,959.16	178,540.84
210301	Гэрэл, цахилгаан	4,300,000.00	4,121,507.16	178,492.84
210302	Түлш, халаалт	35,970,500.00	35,970,452.00	48.00
<b>2104</b>	Хангамж, бараа материалын зардал	24,483,700.00	23,847,380.00	636,320.00
210401	Бичиг хэрэг	3,433,500.00	3,432,180.00	1,320.00
210402	Тээвэр, шатахуун	13,980,200.00	13,980,200.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,954,000.00	2,925,000.00	29,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,154,000.00	1,548,000.00	606,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,962,000.00	1,962,000.00	0.00
<b>2105</b>	Нормативт зардал	1,100,000.00	1,100,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,100,000.00	1,100,000.00	0.00
<b>2106</b>	Эд хогшил, урсгал засварын зардал	16,000,000.00	16,000,000.00	0.00
210604	Урсгал засвар	16,000,000.00	16,000,000.00	0.00
<b>2107</b>	Томилолт, зочны зардал	17,600,000.00	17,588,000.00	12,000.00
210702	Дотоод албан томилолт	17,600,000.00	17,588,000.00	12,000.00
<b>2108</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,981,400.00	44,211,595.60	2,769,804.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,141,700.00	42,642,000.00	1,499,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	916,000.00	916,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	528,000.00	466,777.60	61,222.40
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	210,000.00	77,000.00	133,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	684,000.00	80,000.00	604,000.00
210807	Газрын төлбөр	501,700.00	29,818.00	471,882.00
<b>2109</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	170,706,300.00	165,996,196.60	4,710,103.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	167,956,300.00	163,246,196.60	4,710,103.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,750,000.00	2,750,000.00	0.00
<b>2132</b>	Бусад урсгал шилжүүлэг	7,650,000.00	7,650,000.00	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,000,000.00	7,000,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	650,000.00	650,000.00	0.00
<b>12</b>	Зардлын эх үүсвэр	856,808,200.00	835,481,143.34	21,327,056.66
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	500,000.00	1,061,600.00	-561,600.00
122005	Төсвөөс санхүүжих	856,308,200.00	834,419,543.34	21,888,656.66

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	34,741,263.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34,741,263.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,741,263.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,042,560.00
210402	Тээвэр, шатахуун	12,042,560.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,698,703.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,698,703.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	70,000.00
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	34,811,263.00
35	Нэмэлт санхүүжилт	34,811,263.00
3500	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого	34,811,263.00
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,610,200.00
350014	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,006,063.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого	195,000.00

## 2. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан дараагийн аудитаар тээвэр шатахууны тооцоололд биет горимыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 330,919.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 266,958.7 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 62,203.4 мянган төгрөгийн 4 хугацаатай албан шаардлага, 1,757.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож хүргүүлээ.

### Залруулагдаагүй алдаа:

Аудитаар нийт 63,960.4 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч, 62,203.4 мянган төгрөгийн 4 хугацаатай албан шаардлага, 1,757.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож шаардлага хүргүүлээ.

### 3.1 Төлбөрийн акт

- Хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвийн шууд захирагчид мөнгөн урамшууллыг бусад урамшуулалтай давхардуулан 1,757.0 мянган төгрөгийг олгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.2.-т */Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно./*, Төсвийн тухай хуулийн 6.4.1-д */төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3.-т */хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;/*

### 3.2 Албан шаардлага

- Санхүүгийн албан хаагчдын ажлыг дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр 2,923.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх */Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/*, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх */улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох/*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх */Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно/* 15.1.3 дахь */Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох/*, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь *“/Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна/* заасныг тус тус зөрчсөн.
- Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтны цалинг 100 хувиар тогтоож, 3,530.4 мянган төгрөгийг илүү олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д */төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/*, 16.5.2-т */батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/*, Хөдөлмөрийн тухай хуулийн 57.1. */Ажилтан үндсэн ажлын цагаас бусад цагт үндсэн ажил олгогчоос өөр ажил олгогчтой зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээ байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд үндсэн ажил олгогчдоо мэдэгдэх үүрэгтэй./*, 57.3.3-т */Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4-т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой бөгөөд үүнд ажилтан, үндсэн болон зэрэгцсэн ажил олгогч тус тус хяналт тавина./*, 84.4.-т */Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна./* заасныг тус тус зөрчсөн.
- Баяр наадмын зардлыг жишиг дээд хэмжээнээс 21,750.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх */Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/*, Засгийн газрын 2010 оны 271 дугаар тогтоолын “Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай /наадмын санхүүжилт/”, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11.1.5-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь 1-д */Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван)*

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*сая төгрөг байхаар тус тус тогтоож, бөх, уяач, харваачдад төсвөөс олгох бай, шагналын жишиг хэмжээг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай/ заасныг тус тус зөрчсөн.*

- Төсөвт өртөг нь 34,000.0 мянган төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмжийг худалдан авахдаа тендер зарлалгүй шууд худалдан авалт хийсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д /Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно/, 10.12-д /Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно/, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын хавсралт /Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ./, хавсралтын 2-т /Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар нь бараа, ажлын хувьд – 20.0 сая/ тус тус заасныг;

*Шийдвэрлэсэн нь: Аудитаар зөрчлийг арилгах 4 хугацаатай албан шаардлага, 1 төлбөрийн актыг хүргүүлээ.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл зөрсөн	1	216,958.7			1	216,958.7	1	216,958.7		
Ахмадын байрны их засварыг сайжруулалтаар бүртгээгүй	1	20,000.0	1	20,000.0			1	20,000.0		
Сумын ОНХС-аар авсан гамшгийн үед шаардлагатай бараа материалыг бүртгэлд тусгаагүй.	1	30,000.0	1	30,000.0			1	30,000.0		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>266,958.7</b>	<b>2</b>	<b>50,000.0</b>	<b>1</b>	<b>216,958.7</b>	<b>3</b>	<b>266,958.7</b>	<b>0</b>	<b>0</b>

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвийн шууд захирагчид мөнгөн урамшууллыг бусад урамшуулалтай давхардуулан олгосон.	1	1,757.0	1	1,757.0						
Санхүүгийн албан хаагчдын ажлыг дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр урамшууллыг давхардуулан олгосон.	1	2,923.0			1	2,923.0				
Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтны цалинг 80 хувиар тогтоож, илүү олгосон	1	3,530.4			1	3,530.4				
Баяр наадмын зардлыг жишиг дээд хэмжээнээс хэтрүүлэн зарцуулсан.	1	21,750.0			1	21,750.0				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>29,960.4</b>	<b>1</b>	<b>1,757.0</b>	<b>3</b>	<b>28,203.4</b>				

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс			
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Төсөвт өртөг нь 34,000.0 мянган төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмжийг худалдан авахдаа тендер зарлалгүй шууд худалдан авалт хийсэн.	1	34,000.0			1	34,000.0				
Дүн	1	34,000.0			1	34,000.0				

### 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		